



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 09 одор

Дугаар A/52

Мандалговь

**Гамшигаас хамгаалах орон тооны бус
штаб байгуулах тухай**

Монгол улсын Галын Аюулгүй байдлын тухай хуулийн 16, 17 дугаар зүйл,
Гамшигаас хамгаалах тухай хуулийн 4.1.7, 8.1, 10.1, 13.2.4, 22.8, 24.2 дахь
заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Харуул хамгаалалтын горим шаардлага, галын аюулаас урьдчилан
сэргийлэх, онцгой нөхцөл үүссэн үед асуудлыг таслан зогсоох, болзошгүй
хохирлоос урьдчилан сэргийлэх зорилгоор гамшигаас хамгаалах орон тооны бус
штабыг шинэчлэн 1 дүгээр, Гамшигаас хамгаалах орон тооны бус штабын
гишүүдийн галын багаж тоног төхөөрөмж хариуцсан жагсаалтыг 2 дугаар
хавсралтаар тус тус баталсугай.

2. Ажлын байранд галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг
тогтмол авч, шатах тослох материалтай цаг үргэлж анхаарал болгоомжтой
харьцаж, галын багаж хэрэгслийг эзэмшиж сурх, гал унтраах анхан шатны мэдлэг
чадвартай болж дадлагажсан байхыг гамшигаас хамгаалах орон тооны бус штабын
гишүүдэд үүрэг болгосугай.

3. Галын аюулаас урьдчилан сэргийлэх, онцгой үед ажиллах тухай
төлөвлөгөө гаргаж, сургалт зохион байгуулж ажиллахыг ахлах мэргэжилтэн
/Р.Мөнхбат/, нярав /Э.Мөнхдалай/ нарт тус тус үүрэг болгосугай.

4. Газрын даргын 2018 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн A/09 дугаар
тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ч. ГАНЗОРИГ

431190105